



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/04

Салбардлагай

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2023 онд хийгдэх "Спорт төвийн өргөтгөл" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ч.Үүрцайх (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)
Гишүүдэд: Ж.Өлзийжаргал (6-р багийн Засаг дарга)
Х.Цэрэн (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)
А.Отгонмаа (Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодогч)

2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхолын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх, сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж архивт хүлээлгэн өгөхийг дарга гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЛХАГВАМАНДАЛ

4823020007